

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН БОЛОН ДАГАЛДАХ БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА, ТАЙЛБАР

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд 13-д “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 7.3 дахь зорилтын I үе шатын 1-д “Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.”, 2-д “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.”, мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.14-д “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх...”, 4.2.3.11-д “Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.”, 4.2.3.8-д “Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улс дэлхий нийтийн чиг хандлагыг баримтлан олон нийтэд түшиглэсэн цагдаагийн шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлж ирсэн бөгөөд Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хурлаар батлагдсанаас хойш цаг үеийн шаардлагаар 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Тус хуульд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, тогтолцоо, удирдлага, түүний бүрэн эрх, байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам, албадлагын арга хэмжээг хэрэглэх, үйл ажиллагааны шуурхай, аюулгүй байдлыг хангах, иргэний хяналт, олон нийт цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа, алба хаагчийн эрх зүйн байдал, санхүүжилт зэрэг харилцааг зохицуулж ирсэн.

Иргэдийн амьдралын хэв маяг, соёл, нийгмийн хурдацтай өөрчлөлт, техник, технологийн дэвшил зэрэг хүчин зүйлээс шалтгаалан цагдаагийн байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хүндэтгэх, тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хууль сахиулах ажлын ухагдахуун, ёс зүйг дээшлүүлэх бодлогыг

хэрэгжүүлж, энэ талын онолын болон практик сургалтыг тогтолцоог илүү боловсронгуй болгох, хүний эрхийг хөндөх хязгаарлалт, албадлага шаардсан арга хэмжээг журмаар зохицуулж байгааг зөвхөн хуулиар тогтоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд тогтоомжоор хориглоогүй арга хэрэгслээр нийтэд мэдээ, мэдээлэл түгээх, гадаад улсад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, олон улсын гэрээ, конвенцод тусгагдсан мендезийн зарчмаас хуульд тусгах, ямар ч тохиолдолд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах ижил чиг үүргийн байгууллагууд болох Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагуудын удирдлагыг тодорхой хугацаагаар томилж, чөлөөлөх зохицуулалттай нийцүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй холбогдуулан цагдаагийн алба хаагч эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ тасалдуулахгүй байх, албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх, удирдах алба хаагчийг сонгон шалгаруулах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн сайд батлах замаар төрийн албаны шатлан дэвших /мерит/ зарчмыг хэрэгжүүлэх ажиллагааг шударга, ил тод, нээлттэй болгох зэрэг асуудлыг Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусган боловсрууллаа.

Нэг.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.5, 20.6, 20.7, 20.8 дахь хэсэг:

“20.5.Цагдаагийн төв байгууллагын даргыг дараах тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

20.5.1.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

20.5.2.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.

20.6.Цагдаагийн төв байгууллагын дарга гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол энэ өдрөөс эхлэн түүнийг албан тушаалаас нь огцруулсанд тооцно.

20.7.Хуульд зааснаас бусад үндэслэлээр Цагдаагийн төв байгууллагын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх буюу огцруулахыг хориглоно.

20.8.Цагдаагийн төв байгууллагын дарга нөхөн томилогдвол тэдгээрийн бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 20.1-т заасан бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилнэ.”.

Тайлбар: Цагдаагийн байгууллагын удирдаж байсан дарга нарын томилгоо Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайд солигдох үетэй давхцаж байгаа бөгөөд 1990 оноос хойш энэ 34 жилийн хугацаанд 11 дарга удирдаж байгаа бөгөөд хошууч

генерал Б.Пүрэв, Д.Сандаг-Очир нарыг эс тооцвол бусад дарга нар 2.1 жил тус байгууллагыг удирдаж байжээ.

Мөн тус байгууллагын Тэргүүн дэд даргаар 1990 оноос хойш 8 алба хаагч ажиллаж байснаас дундаж хугацаа нь 4.3 жил, Дэд даргаар 15 алба хаагч ажиллаж байснаас дундаж хугацаа нь 2.3 жил тус тус байна.

Олон улсад цагдаагийн төв байгууллагын дарга нарыг томилох, чөлөөлөх хугацааг авч үзэхэд АНУ-ын муж улс бүр өөр өөрийн цагдаагийн газар, бүтэцтэй, удирдах дарга нарын дундаж хугацаа 4-5 жил (тусгайлан хуулиар зохицуулаагүй), Австралын Хамтын Нөхөрлөлийн Улс хуулиар 7 жилээс ихгүй хугацаагаар томилж, чөлөөлдөг, Бүгд Найрамдах Солонгос Улс Ерөнхийлөгчөөс томилдог бөгөөд хугацаа заасан эрх зүйн зохицуулалтгүй, Япон Улс Ерөнхий сайдын зөвшөөрснөөр Нийтийн аюулгүй байдлын Үндэсний комиссоос томилдог бөгөөд тодорхой хугацаа заасан эрх зүйн зохицуулалтгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад Төрийн албанд мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баримтлахаар заасныг хэрэгжүүлэх, түүнчлэн Тагнуулын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Тагнуулын ерөнхий газрын даргаар төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, сүүлийн 5 жил төрийн албанд тасралтгүй ажиллаж байгаа Монгол Улсын иргэнийг Ерөнхий сайд Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.” гэж тус тус зохицуулсантай адилтган төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг цагдаагийн байгууллагын удирдлагыг мөн тодорхой хугацаагаар томилдог, чөлөөлдөг зохицуулалтыг бий болгох, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны тогтоосон хугацаанаас өмнө чөлөөлөх асуудлыг шийдвэрлэгдээгүй байна.

Тогтвортой удирдлага нь байгууллагын стратегийн зорилго, төлөвлөгөөг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлүүдтэй тулгарах үед зөв шийдвэр гаргах, алба хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, тэдний бүтээмжийг сайжруулах, иргэдийн итгэлийг хүлээх, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх, тогтвортой хөгжлийг хангах зэрэг эерэг үр дүн үзүүлнэ.

Хүснэгт 1.Цагдаагийн төв байгууллагыг удирдаж байсан дарга нарын ажилласан хугацааны талаар

| № | Цол, нэр | Ажилласан он | Агентлагийг удирдсан хугацаа | Засгийн газар өөрчлөгдсөн эсэх |
|----|------------------------|--------------|------------------------------|---|
| 1. | Хошууч генерал Б.Пүрэв | 1990-1996 | 6 жил | 1990-1996 онд МАН сонгуулийн үр дүнгээр төрийн эрх барьсан. 1996-2000 онд АН сонгуулийн үр дүнгээр төрийн эрх барьсан. |

| | | | | |
|-----|---------------------------------|------------------------|-----------------|---|
| 2. | Хошууч генерал Ч.Амарболд | 1996-1998 1999-2001 | 2 жил, 2 жил | 1996.7.19-1998.4.23-нд М.Энхсайханы Засгийн газар. 1998.4.23-1998.12.09-нд Ц.Элбэгдоржийн Засгийн газар. 1999.7.30-2000.7.26-нд Р.Амаржаргалын Засгийн газар. |
| 3. | Цагдаагийн хурандаа Д.Мөрөн | 1998-1999 | 1 жил | 1998.4.23-1998.12.09-нд Ц.Элбэгдоржийн Засгийн газар. |
| 4. | Хошууч генерал Д.Сандаг-Очир | 2001-2006 2008-2012 | 5 жил, 4 жил | 2000.7.26-2004.8.20-нд Н.Энхбаярын Засгийн газар. 2007.11.22 – 2009.10.29- нд С.Баярын Засгийн газар. |
| 5. | Хошууч генерал М.Ганболд | 2006-2008 | 2 жил | 2006.1.25-2007.11.22-нд М.Энхболдын Засгийн газар. |
| 6. | Бригадын генерал Б.Билэгт | 2012-2014 | 2 жил | 2012.8.10-2014.11.5-нд Н.Алтанхуягийн Засгийн газар. |
| 7. | Бригадын генерал Р.Чингис | 2014-2016 | 2 жил | 2014.11.21-2016.7.7-нд Ч.Сайханбилэгийн Засгийн газар. |
| 8. | Цагдаагийн хурандаа Ө.Энхтөр | 2016.12.28- 2017.10 | 10 сар | 2016.7.7-2017.10.4-нд Ж.Эрдэнэбатын Засгийн газар. |
| 9. | Бригадын генерал С.Баатаржав | 2014, 2017-2020 | 4 жил | 2017.10.4-2020, 2020- 2021.1.27-нд У.Хүрэлсүхийн Засгийн газар. |
| 10. | Хошууч генерал Ж.Болд | 2020-2023 | 3 жил | |
| 11. | Бригадын генерал Т.Сүхболд | 2023 оноос | | |

Хүснэгт 2.Цагдаагийн төв байгууллагын Тэргүүн дэд дарга нарын ажилласан хугацааны талаар

| № | Цол, нэр | Ажилласан он | Ажилласан хугацаа | Засгийн газар өөрчлөгдсөн эсэх |
|----|--|--------------|-------------------|---|
| 1. | Цагдаагийн хурандаа Н.Гаравсүрэн | 1991-1995 | 4 жил | 1990-1996 онд МАН сонгуулийн үр дүнгээр төрийн эрх барьсан. |
| 2. | Бригадын генерал А.Дулаанжаргал | 2006-2012 | 6 жил | 2006.1.25-2007.11.22-нд М.Энхболдын Засгийн газар. |

| | | | | |
|----|--|------------|-------|---|
| 3. | Цагдаагийн хурандаа Ш.Ганболд | 2012-2013 | 1 жил | 2012.8.10-2014.11.5-нд Н.Алтанхуягийн Засгийн газар. |
| 4. | Тэргүүн дэд комиссар Ж.Ганбаатар | 2014-2015 | 1 жил | 2014.11.21-2016.7.7-нд Ч.Сайханбилэгийн Засгийн газар. |
| 5. | Цагдаагийн хурандаа Ц.Батсүх | 2015 | | |
| 6. | Бригадын генерал П.Батбаатар | 2016-2017 | 1 жил | 2016.7.7-2017.10.4-нд Ж.Эрдэнэбатын Засгийн газар. |
| 7. | Бригадын генерал Р.Отгонжаргал | 2017-2020 | 3 жил | 2017.10.4-2020, 2020- 2021.1.27-нд У.Хүрэлсүхийн Засгийн газар. |
| 8. | Бригадын генерал Ц.Ням-Очир | 2020 оноос | | |

Хүснэгт 3.Цагдаагийн төв байгууллагын Дэд дарга нарын ажилласан хугацааны талаар

| № | Цол, нэр | Ажилласан он | Ажилласан хугацаа | Засгийн газар өөрчлөгдсөн эсэх |
|----|--|-----------------|----------------------|--|
| 1. | Цагдаагийн хурандаа Д.Алтангэрэл | 1990-1996 | 6 жил | 1996-2000 онд АН сонгуулийн үр дүнгээр төрийн эрх барьсан. |
| 2. | Цагдаагийн хурандаа Д.Базаргүр | 2000 | | 2000.7.26-2004.8.20-нд Н.Энхбаярын Засгийн газар. |
| 3. | Цагдаагийн хурандаа Б.Болдбаатар | 2001-2007 | 6 жил | |
| 4. | Цагдаагийн хурандаа М.Энх- Амгалан | 2008-2012 | 4 жил | 2007.11.22 – 2009.10.29- нд С.Баярын Засгийн газар. |
| 5. | Цагдаагийн хурандаа Н.Амарзаяа | 2014 | | 2014.11.21-2016.7.7-нд Ч.Сайханбилэгийн Засгийн газар. |
| 6. | Цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар | 2015-2015 | 1 жил | |
| 7. | Цагдаагийн хурандаа Д.Амарсайхан | 2014 | | |
| 8. | Цагдаагийн хурандаа Ж.Буянбат | 2015-2016 | | |
| 9. | Дэд комиссар М.Лувсандорж | 2016 | | |

| | | | | |
|-----|---------------------------------------|------------|-------|---|
| 10. | Дэд комиссар Ч.Болдбаатар | 2016-2017 | 1 жил | 2016.7.7-2017.10.4-нд Ж.Эрдэнэбатын Засгийн газар. |
| 11. | Цагдаагийн хурандаа З.Дашдаваа | 2017-2019 | 2 жил | 2017.10.4-2020, 2020- 2021.1.27-нд У.Хүрэлсүхийн Засгийн газар. |
| 12. | Цагдаагийн хурандаа О.Амарсанаа | 2021-2022 | 1 жил | |
| 13. | Цагдаагийн хурандаа П.Оростогоо | 2022-2023 | 1 жил | 2021 оноос Л.Оюун- Эрдэний Засгийн газар. |
| 14. | Цагдаагийн хурандаа Т.Ганзориг | 2023-2024 | 1 жил | |
| 15. | Цагдаагийн хурандаа Н.Мөнхзул | 2024 оноос | | |

2/36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.5, 36.6, 36.7, 36.8, 36.9, 36.10 дахь хэсэг:

“36.3.Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд замын хөдөлгөөнийг биечлэн зохицуулна:

36.3.1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасан төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн замын хөдөлгөөнд оролцоход;

36.3.2.замын хөдөлгөөнд оролцогчдод аюултай нөхцөл байдал үүсэхэд;

36.3.3.эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад;

36.3.4.зам тээврийн осол, гэмт хэрэг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг шаардлагатай үед;

36.3.5.тусгай дуут болон гэрлэн дохио ажиллуулан хойшлуулшгүй албан үүргээ гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэл буюу цуваа өнгөрөхөд.

36.4.Замын хөдөлгөөн зохицуулах техник, хэрэгсэл гэмтсэн, буруу, дутуу ажилласан, эсхүл зохицуулдаггүй уулзвар, гарц, явган хүний гарц, төмөр замын гарам дээр түгжрэл саатал үүссэн тохиолдолд биечлэн зохицуулж болох бөгөөд энэ тухайгаа харьяалах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

36.5.Цагдаагийн алба хаагч энэ хуулийн 36.1-д заасан арга хэмжээ цуцлагдсаны дараа явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг биечлэн зохицуулж, хөдөлгөөнийг хэвийн байдалд оруулна.

36.6.Алба хаагч энэхүү хуулийн 36.1, 36.3-д зааснаас бусад тохиолдолд замын хөдөлгөөнийг биечлэн зохицуулахыг хориглох бөгөөд замын хөдөлгөөнд оролцогчдод хяналт тавьж ажиллана.

36.7.Замын хөдөлгөөний дараах байдлаар зохицуулна:

36.7.1.түр тэмдэг, тэмдэглэл, хаалт, хашилт, гэрлэн дохио, телекамерын удирдлага бүхий нэгдсэн систем, тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоногдсон автомашин, чанга яригч хэрэгсэл зэрэг техник, хэрэгсэл ашиглан;

36.7.2.Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу албан хаагч биечлэн гар, дохиурын хөдөлгөөн, биеийн байрлалаар.

36.8.аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн эзэмшлийн зам, талбайд энэ хуулийн 36.7.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хийж болно.

36.9.Биечилсэн зохицуулалт хийхдээ шүглийн чимээгээр хөдөлгөөнд оролцогчдын анхаарлыг өндөржүүлэн өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангана.

36.10.Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй нөхцөлд гэрэлтдэг дохиуртай, гэрэл ойлгогч бүхий хантаазтай байх бөгөөд бусад нөхцөлд дохиуртай, эсхүл цагаан өнгийн бээлийтэйгээр замын хөдөлгөөн зохицуулж болно.”

3/55 дугаар зүйлийн 55.3, 55.4, 55.5, 55.6, 55.7 дахь хэсэг:

“55.3.Тээврийн хэрэгслийг албадан зогсооход дугуйг хагалж хийг гаргах, дугуйн эргэлтийг сааруулах, дугуйг түгжиж хөдөлгөөнийг хязгаарлах зориулалт бүхий төхөөрөмж, албаны тоноглол бүхий тээврийн хэрэгслийг ашиглана.

55.4.Тээврийн хэрэгслийг дараах байдлаар албадан зогсооно:

55.4.1.тээврийн хэрэгсэлтэй зэрэгцэн очиж зогсох дохио өгч, хашиж хөдөлгөөнийг хязгаарлах;

55.4.2.дугуй хагалах зориулалттай багаж /зараа/-ийг зугтаж яваа чиглэлийг хааж тавих;

55.4.3.том оврын тээврийн хэрэгслээр саад хийх;

55.4.4.дугуйны эргэлтийг сааруулах, түгжих зориулалт бүхий төхөөрөмж ашиглан хөдөлгөөнийг хязгаарлах.

55.5.Цагдаагийн алба хаагч нь тээврийн хэрэгслийг албадан зогсоохдоо боломжтой бүх тохиолдолд зугтсан тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, өнгө, явсан чиглэл, бусад шаардлагатай мэдээллийг харьяалах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авна.

55.6.Энэ хуулийн 55.4.3 дахь хэсэгт заасан саад тавихдаа бүхээгт нь буюу түүний тэвш, чиргүүл дээр жолооч, зорчигч байлгахыг хориглоно.

55.7.Тээврийн хэрэгслийг албадан зогсоох үед иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.”.

Тайлбар: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд 13-д “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...”, 18-д “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж тус тус хуульчилсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8.3-д “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу дараах журам батлагджээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дугаартай тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”. Үүнд:

-Эрэгүүлийн чиглэлийн бүсийг тогтоох, хяналт тавих арга, хэлбэр, зам, замын байгууламж, замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэлд хяналт тавих, зөрчлийг бүртгэж, шийдвэрлэх, зам тээврийн ослын газрыг хамгаалах, тээврийн хэрэгслийг дайчлах, албадан зогсоох, эрэн сурвалжлах, тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх, замын хөдөлгөөнд хяналт тавихад хөтлөх бүртгэл, судалгаа хийхтэй холбоотой харилцааг зохицуулахаар заасан.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуульд хүнийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон бөгөөд замын хөдөлгөөн зохицуулах, тээврийн хэрэгслийг албадан зогсоох зохицуулалт нь журмаар зохицуулж байсныг хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

4/59 дүгээр зүйлийн 59.5, 59.6 дахь хэсэг:

“59.5.Гэмт хэрэг, зөрчлийн талаар олон нийтэд сэрэмжлүүлэх, анхааруулах, шуурхай эрэн сурвалжлах зорилгоор мэдээ, мэдээлэл хүргэх тохиолдолд хүний хувийн мэдээлэл болон тухайн гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийн арга хэлбэрийг дурдахгүйгээр мэдээлж болно.

59.6.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ энэ хуулийн 59.1-д заасан үүргээ хэрэгжүүлснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.”

Тайлбар: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад

баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны мэдээллээс үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд гэмт хэргийн дундаж өсөлт 3.5, зөрчил 9.9 хувийн өсөлттэй байсан бол цаашид хүн ам болон эдийн засаг, эрх зүйн орчны суурь үзүүлэлтүүдийг дагаж гэмт хэрэг, зөрчил ирэх 5 жилд 58.1 хувиар өсөх төлөвтэй байгаа нь нийгмийн хурдацтай хөгжил, бүс нутгийн улс орнуудын үзүүлэх эдийн засгийн болон соёлын нөлөө, хүн амын аж байдалд гарч байгаа өөрчлөлтүүд нь урьдчилан төсөөлөл, таамаглалаас давж байна.

Хууль сахиулж ажиллахад нөлөөлж буй гадаад орчны шинжилгээ буюу системийн динамик судалгаагаар Монгол Улсын нийт хүн ам ирэх 5 жилд (2028 он хүртэл) 3,663,149 буюу 2023 онтой харьцуулахад 5.6 хувиар, дотоодын нийт бүтээгдэхүүн 2028 он гэхэд 101,150,783.1 сая төгрөг буюу 3.15 дахин тус тус нэмэгдэх тооцоолол гарсан бөгөөд уг хамаарлыг тооцож үзэхэд цагдаагийн байгууллагын одоогийн бүтэц, зохион байгуулалт, арга барилаар ирээдүйд гарах гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэж, иргэдийн аюулгүй тайван байдлыг тогтвортой хангаж ажиллахад ихээхэн хүндрэл сорилттой тулгарна гэсэн судалгаа гарсан.

Мөн цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд нийгэмд аюултай гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлах зорилгоор олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх хуулийн зохицуулалт шаардлагатай байгаа юм.

5/67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг:

“67.5.Цагдаагийн байгууллагын удирдах алба хаагчийг сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.”.

Тайлбар: Удирдах албан тушаалтныг ил тод, шударга байдалд суурилсан байдлаар сонгон шалгаруулалтаар томилох нь тухайн алба хаагчийн ажиллах мэдлэг, ур чадвар, туршлага, төрийн зорилго, зорилтыг биелүүлэхэд тохирох эсэх зэргийг үнэлэх боломж бүрдэх бөгөөд алба хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, байгууллагын хөгжлийг дэмжихэд ач холбогдолтой.

6/68 дугаар зүйлийн 68.10 дахь хэсэг:

“68.10.Үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцохоос татгалзах үүрэгтэй.”.

Тайлбар: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаартай тогтоолоор Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын "..., үйлдвэрчний эвлэлийн ..., үйлдвэрчний эвлэлийн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн гэж хүчингүй болгосон.

Дээрх хэсгийг нэмснээр цагдаагийн алба хаагч үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх, цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэхдээ байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх, хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тасралтгүй хэрэгжүүлэх юм.

7/69 дүгээр зүйлийн 69.1.13 дахь заалт:

“69.1.13.хөдөлмөрийн маргаан зохицуулах зорилгоор албан үүргээ орхих;”

8/80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг:

“80.4.Энэ хуулийн 80.1-д заасан үндэслэлээр бүрэн эрх нь түдгэлзсэн цагдаагийн алба хаагчийн албан үүргийг эрх бүхий албан тушаалтан цагдаагийн өөр алба хаагчаар түр орлон гүйцэтгүүлж болно.”

Тайлбар: *Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зарим тохиолдолд алба хаагч тушаалаар томилсон нутаг дэвсгэрт очиж үүрэг гүйцэтгэхгүй, улмаар хот суурин газарт ажиллана гэж маргаан үүсгэх зэргээр байгууллагын хэвийн үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлого, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргаж буй тохиолдлыг цагдаагийн алба хаагчийн хориглох зүйлд тооцох шаардлагатай байх тул хөдөлмөрийн маргаан зохицуулах зорилгоор албан үүргээ орхих үйлдлийг хязгаарлах, мөн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бүрэн эрх нь түдгэлзсэн цагдаагийн алба хаагчийн албан үүргийг эрх бүхий албан тушаалтан цагдаагийн өөр алба хаагчаар түр орлон гүйцэтгүүлэх зохицуулалтыг тусгах шаардлага үүссэн.*

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2018-2025 онд 37 алба хаагчийн албан үүргээ биелүүлэх бүрэн эрхийг түр түдгэлзүүлсэн бөгөөд энэ тохиолдолд Төрийн албаны тухай хуульд зааснаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх (албан үүргийг хавсран гүйцэтгэх) замаар шийдвэрлэж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар сахилгын хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд томилогдсон ажилд очихгүй байх, ажил хаяж явах зэрэг 12 тохиолдол байна. Энэ нь албаны хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч байна.

2 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэсний дараа “6 жилийн хугацаагаар” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “мэдүүлэг өгөхгүй байх” гэсний дараа “, хууль зүйн туслалцаа авах” гэж, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “байрлахыг” гэсний дараа “, эсхүл эрх бүхий байгууллагад хамт очихыг” гэж, 36 дугаар зүйлийн “хаах” гэсний дараа “, замын хөдөлгөөн зохицуулах” гэж, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсгийн “хангах үүргийг” гэсний дараа “тухайн аймаг, сумын Засаг дарга болон” гэж, 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсгийн “суманд” гэсний дараа “болон суурин бус газарт” гэж, 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсгийн “тусгай хэрэгсэл,” гэсний дараа “дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх техник, хэрэгсэл,” гэж, 97 дугаар зүйлийн 97.2 дахь хэсгийн “заналхийлсэн” гэсний

дараа “, зөвшөөрөлгүйгээр дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн” гэж тус тус нэмсүгэй.

Тайлбар: Цагдаагийн байгууллага нь өнөөдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 110 гаруй хууль, 153 эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж, хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийн хүрээнд Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 бүлэг 213 зүйл 446 хэсэгт заасан гэмт хэргүүдээс Тагнуулын байгууллагад шууд харьяалал тогтоосон 31 зүйл, 1 хэсэг, өөрсдөө илрүүлсэн 4 зүйл, 1 хэсэгт, Авлигатай тэмцэх газарт шууд харьяалал тогтоосон 11 зүйл, өөрсдөө илрүүлсэн 1 зүйлд, Цагдаагийн байгууллага 171 зүйл, 366 хэсэгт тус тус мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 17 бүлэг, 255 зүйл, 1058 хэсэг, 908 заалттай бөгөөд тус хуулийн тусгай ангид нийт 2.300 орчим үйлдлийг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар байгаа зохицуулсан зөрчлүүдээс Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан 15 зүйл, 26 хэсэг, 4 заалт, Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан 2 зүйл, 5 хэсэг, 3 заалт, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан 82 зүйл, 295 хэсэгт заасан зөрчлийг харьяалан шалгаж, үүнээс 98 зүйлийн 332 хэсэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд өнгөрсөн 5 жилд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн статистик тоон мэдээлэл, нийгэм, эдийн засаг (хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн, боловсрол, эрүүл мэнд, дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляц, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ, долларын ханш, ажилгүйдэл, ядуурлын түвшин, согтууруулах ундааны хэрэглээ) зэрэг хүчин зүйлийг “Системийн динамик загварчлал”-д оруулан туршилт /симуляц/ хийхэд 2026 онд 9286 буюу 26.1, 2030 онд 18402 буюу 51.7, 2040 онд 31442 буюу 88.4 хувиар тус тус өсөх тооцоолол гарсан.¹

Мөн үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдэлд хохирол учруулахуйц эмх замбараагүй байдлыг дэвэргэх гэсэн сонирхол бүхий этгээдүүдэд хуулийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, улс төржүүлэх, хууль сахиулагчдын нийтийн эрх ашгийн төлөө тавьсан шаардлагыг эсэргүүцэх, хууль зөрчих зэрэг үйлдэл гарах болсон.

Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтаар сүүлийн 5 жилд шалгагдсан алба хаагчдын 67.7 хувь нь буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөл байдлаас шалтгаалан алба хаагчийн үүрэг гүйцэтгэх үед энгэрийн камер, тээврийн хэрэгсэлд байх камерыг нэмэгдүүлэх, байнга ашиглах замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн.

Энгэрийн камер нь цагдаагийн алба хаагчдын үйлдэл болон иргэдтэй хийсэн харилцааны талаар бодит баримт бүрдүүлж, олон нийтийн болон алба хаагчдын хооронд үүсэж болох зөрчил, маргааныг шийдвэрлэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, алба хаагчдын үйл ажиллагааг ил тод болгох, мэргэжлийн үйл ажиллагааг сайжруулах, хууль бусаар үйлдэгдэж болохгүй гэмт хэргээс сэргийлж, ёс

¹ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас гаргасан мэдээлэл 2024 он

зүйн дүрэм, хэм хэмжээг баримтлах, хяналт тавих боломжийг бүрдүүлэхээс хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх эерэг үр дүн гарна.

3 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/17 дугаар зүйл:

“17 дугаар зүйл.Цагдаагийн албаны сургалт

17.1.Цагдаагийн албаны сургалт нь мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалтаас бүрдэнэ:

17.1.1.цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг мэргэшүүлэх сургалт;

17.1.2.цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг ур чадвар хөгжүүлэх сургалт;

17.1.3.энэ хуулийн 17.1.1, 17.1.2-д зааснаас бусад сургалтыг албан тушаалын буюу ажлын байрны сургалт.

17.2.Цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулга, журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.4.Цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалт явуулах төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно.

17.5.Цагдаагийн алба хаагч энэ хуулийн 17.1-д заасан сургалтад 3 жил тутам хамрагдсан байна.

17.6.Энэ хуулийн 17.4-д заасан төв нь албаны нохой ашиглах болон Галт зэвсгийн тухай хуулийн 10.4-т заасан болон гэрээт харуул хамгаалалтын сургалтыг төлбөртэй зохион байгуулж болно.

17.7.Энэ хуулийн 17.5-д заасан сургалтын төлбөрийн хэмжээг дотоод хэргийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.”

Тайлбар: *Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна”, мөн хуулийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.”, Цагдаагийн албаны тухай хуулийн 21.1.11-т “Хүний*

нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, мэргэшлийн зэрэг олгох”, Дотоодын цэргийн тухай хуулийн 32.4 дэх хэсэгт “Дотоодын цэргийн алба хаагч энэ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн мэдлэг олгох, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техник хэрэгсэл бэлтгэл, сургалтад заавал хамрагдсан байна” гэж цагдаагийн алба хаагчийг сургах эрх зүйн үндэслэлийг тус тус тогтоосон байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 17.2.-т “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэж зааснаар цагдаагийн албаны сургалтын тогтолцоог тодорхойлсон гэж үзэж болох юм. Мөн албаны нохой ашиглах, галт зэвсэг ашиглах болон гэрээт харуул хамгаалалтын сургалт, шийтгэл хүлээсэн алба хаагчийн хамрагдах ёс зүйн сургалтууд тус тус хуульд тусгалаа олжээ. Бусад сургалтын талаар Цагдаагийн албаны тухай хуульд нарийвчлан тусгаагүй байна.

Улс орнуудын цагдаагийн байгууллагын нийтлэг зорилго нь нийгмийн аюулгүй, амар тайван байдлыг хамгаалах, түүнд үйлчлэх явдал юм. Гэсэн хэдий ч үйл ажиллагаа явуулах арга барил нь тодорхой шалтгааны улмаас өөр байж болно. Цагдаагийн алба хаагчийн сургалт нь цагдаагийн байгууллагын чиг үүрэг хэрхэн хэрэгжихийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг юм.

Монгол Улсад цагдаагийн алба хаагчийг сургах боловсрол, сургалтын тогтолцоог онцгой анхаарч Засгийн газраас үе шаттайгаар, тасралтгүй хөгжүүлэхээр бодлогын баримт бичгүүдэд тусгаж ирсэн ч хэрэгжилт хангалтгүй, сургалтын нэгдсэн тогтолцоог оновчтой тодорхойлоогүй байна.

Цагдаагийн албаны сургалтын оновчтой тодорхойлох нь цагдаагийн байгууллагын алба хаагчдад шаардлагатай мэдлэг, ур чадвар, зан үйлд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Оновчтой сургалт нь алба хаагчдын мэргэжлийн түвшнийг өндөрсгөж, байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй болгох, ажлын ур чадварыг сайжруулах, эрсдэлийг удирдах чадвар, шударга ёсыг хангах, мэргэжлийн ёс зүйн боловсрол, итгэлцлийг бий болгох, тусгай хэрэгсэл, техник технологийн ашиглалт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны чанар, үр ашгийг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой.

Иймд цагдаагийн албаны сургалт нь алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, шударга ёсыг сахихад зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь байгууллагын нийт үйл ажиллагааны үр дүнг сайжруулах гол хүчин зүйл юм.

Цагдаагийн байгууллага нь мэргэшүүлэх сургалтыг холбогдох журмууд болон хөтөлбөртөө тусгайлан тусгасан байгаа хэдий ч гадаад орнуудын жишгийг харгалзан дотоодын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн үндсэн сургалтын төрөл болгож хуульчлах шаардлагатай байна.

4 дүгээр зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.” гэснийг “ойлгомжтой хэлбэрээр

илэрхийлж, итгэл төрүүлэхүйц байдлаар харилцах үүрэгтэй.”, мөн зүйлийн 22.7 дахь хэсгийн “тээврийн хэрэгсэлд дуу-дүрсний бичлэг хийх техник, хэрэгслийг суурилуулан ашиглаж болно.” гэснийг “тээврийн хэрэгсэлд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх техник, хэрэгслийг суурилуулан ашиглана.”, 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалтын “гэмт хэргийг” гэснийг “гэмт хэрэг, зөрчлийг” гэж, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “үйлдэнэ.” гэснийг “үйлдэж, гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол даруй буцаан хүлээлгэн өгнө.” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн” гэснийг “мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны” гэж тус тус өөрчилсүгэй.

Тайлбар: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхийн тулд гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмаас хуульд тусгах, цагдаагийн алба хаагчаас эд зүйл, баримт бичиг түр хураан авах тодорхой ажиллагаа явуулахдаа хүний эрхийг хангах үүднээс гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол тухайн зүйлийг даруй буцаан өгөх нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах зарчимд нийцүүлэх зорилгоор дээрх өөрчлөлтийг оруулсан.

5 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.12 дахь заалтын “дээд цолноос бусад” гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн 80.1.1 дэх заалтын “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор,” гэснийг, 88 дугаар зүйлийн 88.3 дахь хэсгийн “дээд цолтой алба хаагчийн дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, цагдаагийн бусад” гэснийг, 91 дүгээр зүйлийн 91.1.4 дэх заалтын “цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсгийн 91.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.

Тайлбар: Монгол Улсын Их Хурлаас 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-аар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч албан тушаалыг мөрдөгч гэж өөрчилсөн, мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр “73.1.1.дээд цол: цагдаагийн генерал, цагдаагийн дэслэгч генерал, цагдаагийн хошууч генерал,” гэсэн заалтыг хүчингүйд тооцсон тул дээрх хэсэг, заалтуудыг хассан.

Хоёр.Дотоодын цэргийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслийн талаар:

1 дүгээр зүйл.Дотоодын цэргийн тухай хуулийн 32 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/32.5.Дотоодын цэргийн алба хаагчийн албаны сургалтыг Цагдаагийн албаны тухай хуулийн 17 зүйлд заасныг баримтлан зохион байгуулна.

Тайлбар: Дотоодын цэргийн тухай хуулийн 7.2-д “Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байна.”, 38.2-д “Дотоодын цэргийн санхүүжилт, аж ахуй, материал-техникийн хангалтыг цагдаагийн төв байгууллага хариуцна.” гэж тус тус заасан бөгөөд сургалтын үйл ажиллагааг цагдаагийн байгууллагад явуулж буй сургалттай уялдуулах шаардлагатай гэж үзсэн.

Гурав.Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1 дүгээр зүйл. Дипломат албаны тухай хуульд дараах заалт нэмсүгэй.

1/13¹ дугаар зүйлийн 13^{1.2} дахь хэсэг:

“13^{1.2.13.цагдаагийн атташе.”.}

2 дугаар зүйл.Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “Цэргийн” гэсний дараа “болон цагдаагийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Дипломат албаны тухай 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “цэргийн алба хаагчийн хувьд” гэснийг “цэрэг, цагдаагийн алба хаагчийн хувьд” гэж өөрчилсүгэй.

Тайлбар: Дэлхий дахинд үндэстэн дамнасан зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн үйлдлийн арга, зохион байгуулалтын хэлбэрийг илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учруулж, нэг улсын хил хязгаараас давж, улс орон дамжин үйлдэгдэх хандлага нэмэгдсэн, хэд хэдэн улсын цагдаагийн байгууллага хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага үүссэн, мөн манай улсын иргэдийн гадаад улсад зорчих тоо жил ирэх тусам өсөж байгаатай холбоотойгоор гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмт хэрэг, зөрчлийн улмаас өртөж хохирох, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдөх явдал нэмэгдсээр байна.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 1.3-д “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломат аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.”, 6.25-д “Гадаад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бодлогын зорилго нь хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалахад оршино” гэж, 6.27.6-д “Гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг ноцтой гэмт хэрэгт өртөхөөс сэрэмжлүүлэх, ийм төрлийн хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах чиглэлээр тухайн улсын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах” гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4.1-д “Иргэдийн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулна.”, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлнэ” гэж, 3.4.4.4-т “Нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ” гэж тус тус зохицуулсан.

Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээллээр 2024 оны гуравдугаар улирлын байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг дэлхийн 20 гаруй улсын цагдаа, хууль сахиулах

байгууллагад Монгол Улсын 216 иргэн хууль бусаар оршин суух, танхайрах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хулгайлах, хүчиндэх, биеэ үнэлэх, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, залилан мэхлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, нэвтрүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, журам зөрчих, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг гэмт хэрэг, зөрчилд холбогдон саатуулагдан шалгагдаж байгаа төдийгүй 202 иргэн дээрх төрлийн гэмт хэрэгт шийтгэгдэн 3 сараас 25 жилийн хугацаатай хорих ял эдэлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 238, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 388 бүртгэгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд тухайн төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр бүс нутгийн төдийгүй олон улсын цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай шуурхай, нягт хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Консулын дүрэм”-д заасан Монгол Улсаас гадаад улсад суугаа Консулын төлөөлөгчийн газрын гүйцэтгэх үүргийн хувьд Цагдаагийн атташегийн гүйцэтгэх зарим төрлийн ажил үүрэгтэй давхцаж буй мэт боловч үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, гадаад улсын цагдаа, хууль сахиулах байгууллагатай мэдээ, мэдээлэл шуурхай солилцох замаар таслан зогсоох мэргэшсэн үйл ажиллагаа явуулах, хилийн чанад дахь монгол соёл иргэншлийн өвийг сурвалжлан олох, эх орондоо эгүүлэн залах, буцаан авчрах чиглэлээр хамтран ажиллах, гадаад улсад ажиллаж амьдардаг, суралцдаг, дамжин өнгөрч буй болон аялж буй Монгол Улсын иргэдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль зүйн туслалцаа үзүүлэх ач холбогдолтой юм.

Энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинээр ямар нэг эрх зүйн дэд бүтэц үүсгэх, хөрөнгө зардал гаргах зэрэг эдийн засгийн үр дагавар үүсэхгүй.

---оОо---